



УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ТҮНШЛЭЛД ТУЛГУУРЛАН ҮЙДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГЫГ ЧАНАРЖУУЛАХ АРГА ЗАМ

/ХАБ,ЭА-Н МЭРГЭЖЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Бловсролын ухааны магистр, Химийн, биологийн ахлах багш:

М. Дэлгэрням

Боловсролын ухааны магистр, ахлах багш ХАБЭА багш:

Б.Энхцэцэг

Чойр хот

2020

ТОВЬЁОГ

ОРШИЛ

- Удиртгал
- Илтгэлийн хураангуй
- Түлхүүр үг
- Судалгааны үндэслэл
- Судалгааны зорилго
- Судалгааны зорилт
- Судлагдсан байдал
- Судалгааны аргууд
- Судалгааны шинэлэг тал

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ-ОНОЛЫН ХЭСЭГ

- Онолын хэсэг
- Нэр томьёоны тайлбар

ХОЁРДУГААР БҮЛЭГ-СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- Судалгааны хэсэг
- Судалгааны дүгнэлтүүд

ДҮГНЭЛТ

- Илтгэлийн дүгнэлт
- Шинэ санаа, санаачлага

НОМ ЗҮЙ

ХАВСРАЛТ

Оршил

Удиртгал

Орчин үед шинжлэх ухаан технологийн эрчимтэй хөгжлийг дагаад хүүхдийн сэтгэхүй, оюун ухаан юмсыг хүлээн авах , тэдгээрт хандах хандлага эрс хурдацтай хөгжиж буй өнөө үед хүний хөгжил, сургалтын чанар, нийгмийн хэрэгцээ эрэлтэд нийцсэн, өндөр мэдлэг боловсролтой, хөрвөх чадвартай, өөрийгөө хөгжүүлэх арга технологийг эзэмшисэн , өөрийн ажилдаа дур сонирхолтой боловсон хүчинг бэлтгэж гаргах нь чухал болоод байна.

Тиймээс ХХI зууныг тогтвортой хөгжил , хүний эрх, ардчилсан зуун болгох эрхэм зорилтын хүрээнд МБС-ын салбарт шинэ өөрчлөлтүүдийг хийсэн билээ.

Сүүлийн 10 жилд хийгдсэн МБС-ын шинэчлэл нь боловсролын агуулгын, зорилгын, технологи, хүний нөөцийн гэсэн 4-н хүрээг хамарч эргэлтийн шинж чанартай болгосон бөгөөд уг салбарын хөгжлийн нэг үр шим нь хамтын ажиллагаа хэмжээн авч үздэг болсон байна.

Энэ өөрчлөлтөд боловсролын байгууллага нь хүрээлэн буй гадаад орчны өөрчлөлтөд зохицох чадвар , дотоод харилцаа холбоог сайжруулах, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх чадавхийг нэмэгдүүлэхийн тулд байгууллага хоорондын хамтын ажиллагаа чухал болж байна.

Хураангуй :

Мэдээлэл технологийн хөгжил, мэдлэг чадварт суурилсан эдийн засгийн эрин үед маш хурдтай, байнгын өргөн тархацтай өөрчлөлтүүд хийгдэх болж Мэргэжлийн боловсролын салбарын өмнө тулгарч байгаа асуудлуудын нэг бол хамтын ажиллагааг тогтворжуулах, тэднийг байнгын хөгжил хөдөлгөөнд байлгах нөхцөл бүрдүүлэх, хөгжүүлэх явдал чухал юм.

Түлхүүр үг

МБС-ын байгууллаг, нийгмийн түншлэл, хөгжил , хамтын ажиллагаа, харилцаа холбоо, багш, суралцагч, сургалтын байгууллага

Судалгааны үндэслэл:

Дэлхийн нийтээр даяарчлагдан шинжлэх ухаан, мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, улс төр эдийн засгийн интеграчлал өргөжиж байгаа өнөө үед мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ур чадвар бүхий чанартай мэргэжилтнийг бэлтгэн нийлүүлэх нь улс орны анхаарлын төвд байх асуудлуудын нэг билээ.

Энэхүү асуудлын хүрээнд мэргэжлийн боловсрол сургалтын салбарын шинэчлэл нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжих шаардлагатай байна.

Тиймээс энэхүү сонирхолтой асуудлыг сонгон авч шийдвэрлэх санал дэвшүүлсэн болно.

Зорилго:

Нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, үр дүнтэй хамтын ажиллагааны хөшүүргийг бий болгох, оновчтой зөв зохион байгуулалт бүхий эерэг үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх арга зам боломжийг судлана.

Зорилт:

- ✓ Салбарын нэр хүнд, ач холбогдолыг сурталчилан таниулах замаар төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд салбар зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлага
- ✓ Хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга замаар багш, суралцагчийг хөгжүүлэх боломж
- ✓ Өндөр хөгжилтэй орнуудаас Монголд хэрэгжүүлж болохуйц туршлагууд
- ✓

Сэдвийн судлагдсан байдал :

Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих явц, түүндээ сэтгэл хангалуун байдал ханамжийн тухай мөн түүнд нөлөөлж буй хүчин зүйлс болох бидний сонгосон энэхүү сэдвийн хүрээнд нийтлэг ерөнхий тогтолцоог илрүүлсэн, энэ түвшинд хийсэн онолын болон хэрэглээний суурь судалгаа өнөө хэр хийгдээгүй байна. Гэхдээ уг сэдвийн хүрээнд

болон түүнтэй холбогдох, хамаарах олон асуудлыг авч үзсэн 2016-2021 оны салбарын бодлогын баримт бичиг болон судалгааны ажил, хэлэлцүүлэгийн материал олон буйг бас тэмдэглэж байна.

Судалгааны арга

Уг илтгэлийг бичихдээ угсаар санал асуулга, ажиглалт, анкетын арга, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, харьцуулах арга, туршилт хийх гэх мэт аргуудыг ашиглав.

Судалгааны шинэлэг тал

Нийгмийн түншлэл, мэргэжлийн холбоод ажил олгогчдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх замаар багш, суралцагчдын хөгжил, үйлдвэрлэлийн дадалга хийх боломжийг судалсанаараа шинэлэг юм.

НЭГ: ОНОЛЫН ХЭСЭГ

МБСын тухай хуулинд нийгмийн түншлэлийн тухай ийнхүү заасан байна.

20 дугаар зүйл. Нийгмийн түншлэл

20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг сонирхогч этгээд нэгдэн нийгмийн түншлэлийг бүрдүүлнэ.

20.2.Нийгмийн түншлэл нь дараахь чиглэлээр хамтран ажиллана:

20.2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого боловсруулахад оролцох;

20.2.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, нөхцөлийг

сайжруулах;

20.2.3.Мэргэжлийн хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, сургалтын агуулга,

стандарт боловсруулахад оролцох;

20.2.4.Үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран зохион байгуулах;

20.2.5.Багш нарын мэргэшил дээшлүүлэх;

20.2.6.Мэргэжлийн шалгалт хамтран авах;

20.2.7.Төгсөгчийг ажлын байраар хангах;

20.2.8.Багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

20.2.9.Үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;

20.2.10.Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

20.3. Салбар, үйлдвэрийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа энэ хуулийн 6.1-д заасан

Зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно гэж заасан байна.

✓ 2019 оны 10 сарын 03 нд Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн санаачлагаар МБС-ын багш нарын уулзалтын үеэр гарсан 18 хүний гарын үсэг бүхий "Мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн харицан ойлгоцол, хамтын ажиллагааны санамж бичиг" ийн хүрээнд :

- Коллежийн суралцагч, оюутнуудыг далаггажүүлэх,
- Тэтгэлэг урамшуулал олгох
- Ажлын байраар хангах,
- Хамтарсан туршилт судалгааны ажлууд гүйцэтгэх,
- Сургалтын стандарт, хөтөлбөр, технологи, үйл ажиллагааг сайжруулах
- чиглэлээр хамтран ажиллана.
- Суралцагч, оюутан, багш нараа харицан солилцож далаггажүүлэх,
- Туршлага судлуулах гэсэн ажлуудыг хийх чиглэл гарсан байна.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшлийн үр чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааны үр дүн нь:

✓ нэгдмэл зорилго,

✓ олон талын оролцоо,

✓ зөвшилцөл,

✓ хамтын ажиллагаанаас шууд шалтгаалах учир МБС-ын салбарын нийгмийн

түншлэл, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, харицан уялдаа, үүрэг хариуцлага нэн чухал гэдэгт санал нэгдсэн байна.

Тус санамж бичгийн

4.5. Компаний удирдлага нь аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан-үйлдвэрлэлийн

далдлагажүүлэгчийг сургаж бэлтгэх, даллагын сургалтыг удирдах боломжоор хангахад

дэмжлэг үзүүлэх;

4.7. МБС-ын хөдлөлөнгийн үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэхэд ажиг олгогч,

мэргэжлийн

холбоод, өндөр мэргэшсэн инженер, техникийн ажилтантай идэвхитэй хамтран

ажиллах хэрэгтэй гэж бичжээ.

МАОЭНХ-ны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар:

- ✓ Манай ажил олгогч эздийн хувьд МБС-аар шаардлагагүй мэргэжлээр сургаж байна, төгссөн хүүхэд нь чадваргүй, шаардлага хангадаггүй гээд шүүмжлээд суудаг байсан.
- ✓ Ажил олгогчид шүүмжлэх биш, хэрэгтэй байгаа мэргэжлээрээ ийм чадвартай хүн бэлтгэж өгөөч гэдэг захиалгаа сургуулиудад өгдөг,
- ✓ Захиалгынхаа дагуу сургууль хэрхэн бэлтгэж байгаад нь анхаарал тавьдаг,
- ✓ Дадлага хийх бололцоогоор нь хангасны эцэст төгсөнгүүг нь авч ажиллуулдаг хамтын ажиллагааны суурийг бүрдүүлэхэд анхаарах учиртай юм./ Д.Алимаа-Хамтран ажиллах боломж РР аас / гэж дурдсан байгаа нь ААН-үүд ямар ажилтан хэрэгтэй байгаа тодорхойлон захиалдаг түүний дагуу хяналт тавьдаг дадлага хийх боломжийг бүрдүүлэн харилцан туслалцах, дэмжин ажиллах нь зүйтэй гэжээ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ 11 САРЫН 09 НЫ ӨДРИЙН 370
ДУГААР ТОГТООЛ**

**НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР
АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1.1.Хамтын хэлэлцээр байгуулсан яамдын сайдын болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлд салбар, тухайн нутаг дэвсгэрийн ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын төлөөллийг оруулна. Энэ заалтад Батлан хамгаалахын сайдын зөвлөл хамаарахгүй; (Энэ заалтад Засгийн газрын 2019 оны 386 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

1.2.Аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хамтын хэлэлцээр байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдлыг

нийгмийн түншлэгч талууд хамтран дүгнэлт гаргах; (Энэ заалтад Засгийн газрын 2019 оны 386 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

1.3.Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хөдөлмөр, нийгмийн зөвшлийн талуудын хяналтыг өндөржүүлэх чиглэлээр тухайн шатны мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

2. Эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хүн амын бодит орлогыг хамгаалах хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд нийгмийн түншлэлийн оролцоог хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллахыг холбогдох сайд нарт даалгасугай:

2.1.Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үнэ тогтворжуулах хөтөлбөр, арга хэмжээнд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын оролцоог хангаж ажиллах;

2.2.Инфляцийн түвшин, салбарын онцлог, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

3. Нийгмийн түншлэлийн талаар хэрэгжүүлсэн ажил, үр дүнг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын ажлыг дүгнэх үзүүлэлт болгон тооцож, хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт, мөн энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг жил бүр Засгийн газарт танилцуулахыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятавт тус тус даалгасугай.

ХОЁР: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Төр хувийн хэвшлийн туншлагийн бэхжүүлэхэд салбар зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоот нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлага

Гадаадын орнуудын туршлагаас үзэхэд мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэхдээ ажил олгогчдын оролцоонд тулгуурлан үр дүнд хүрсэн байдаг. Үүний гол үндэс нь нийгмийн туншлагийг бодитоор хэрэгжүүлж чадсан явдал юм.

Нийгмийн туншлаг гэдэг ойлголтыг манай улс анх техник мэргэжлийн сургуулиудыг байгуулж байхдаа хамтран ажиллах үйлдвэрүүдийг бий болгож 1991 оны эхэн үе хүртэл мөрдөж байсан.

МБС-д хувийн хэвшлийн оролцооны идэвхийг харуулах зүйл нь сургуулийн үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаагаар тодорхойлно.

Жишээ нь:

1. Сургууль төвтэй загварыг суралцагч + туншлаг бүхий загвараар солих

- ✓ Сургалтын стандарт боловсруулахад оролцуулах –
- ✓ Аймар, бүс нутгийн хэмжээнд мэргэжлийн үр чадварын уралаан зохион байгуулах / багш, суралцагч, ажилтан / -

- ✓ Төрсөлтийн үнэлгээ, диплом хамтаалагтанд оролцуулах – Энэ үйл ажиллагаанд манай сургуулийн хувьд ААН-ийн төлөөллийг үнэлгээ зохион байгуулах үйл ажиллагаанд оролцуулдаг хэдий ч яг ажил олгогчийн зүгээс сургалтын төлөвлөгөө, сургалтын агуулга, суралцагчийн мэдлэг чадвар хэр нийцэж, шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргадаггүй.

2. Сургалт зохион байгуулах

- ✓ Шинээр элсэгч оюутан суралцагчид аж ахуй нэгж ажил олгогчдыг урин “ Мэргэжил бүхэн сайхан” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг яришлагыг тогтмол зохион байгуулах. Аж ахуйн нэгж компаниудаар очиж хэсэгчилэн танилцуулах – Энэ тал дээр манай сургууль үлгэр жишээ болохуйц үйл ажиллагаа зохион байгуулдаг ба төрсөгчид, ААН төлөөллийг оролцуулан уулзалт яришлага, хэлэлцүүлэг зохион байгуулж байсан ба энэ суралцагчийн

мэргэжлийн үнэ цэнэ мэргэжилдээ сонирхолтой болох зэрэг ач холбогдолтой байдаг билээ.

- ✓ Мэргэжлийн хяналт, халамжийн байгууллагаас жилд нэгээс доошгүй удаа аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулдаг бөгөөд түүнд ХАБ,ЭА-н багш оюутнуудаа идэвхитэй оролцуулах
- ✓ Албан байгууллага бүрийн ХАБ,ЭА-г хариуцсан ажилтантай цаашид хэрхэн хамтран ажиллах талаар ярилцах, судалгаа авах

3. Байнгын эргэх холбоотой ажиллах

Энэ ажиллагааг тогтворжуулах үүднээс баг бүрдүүлж ажиллах. Нийгмийн түшлэл байгуулах. Жишээ нь Манай сургууль нь 5 ААН тэй хамтран ажиллах гэрээтэй бөгөөд гэрээнд талуудын оролцоо, хэрхэн хамтран ажиллах талаар тусгасан байдаг. Харамсалтай нь гэрээний биелэлтийг тэр бүр дүгнэдэггүй байгаагаас хамтын ажиллагаа хангалтгүй байгааг илтгэж байна.

- ✓ Энэ нь хамтын ажиллагааг нэг уулзаад орхигдуулах бус тогтмол оролцоотой байлгах төлөвлөгөөг боловсруулах. Тиймээс бидэнд нийгмийн түншлэлийн алба зайлшгүй шаардлагатай.
- ✓ Багш солилцооны хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- ✓ Төр хувийн хэвшлийн болон олон талт оролцоот санхүүгийн механизмыг нэвтрүүлэх

Тиймээс маркетингийн үйл ажиллагааны зардалын тодорхой хэсгийг түншлэгчдийг татах ажилд зарцуулахаар тусгаж өгөх

Хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга замаар багш, суралцагчдыг хөгжүүлэх боломж


Мэргэжлийн боловсролын салбарын төгсөгчдийн ур чадвар нь ЧСС-ын хөтөлбөр, багшийн ур чадвар, сургалтын орчин дадлагаас ихээхэн хамаардаг билээ. Өөрөөр хэлбэл мэргэжлийн сургалтын гол цөм нь үйлдвэрлэлийн дадлага юм. Иймээс ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангах, гадны ажиллах хүчийг орлох ур чадвартай мэргэжилтэй ажилтныг бэлтгэх хэрэгцээг одоо хэрнэ байсаар л байна. Тухайлбал жилд дунджаар 27,5 мянган гадаад */Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвийн тайлан/* иргэн Монгол улсад ажиллаж байна. Гадаад ажилчдын дийлэнх хувь нь барилга, уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь гадны ажиллах хүчний импортыг бууруулж, дотоод мэргэжилтэй ажилтнаар орлуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Хэдийгээр ЧСС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багшийг хөгжүүлэх чиглэлээр олон талт ажилууд хийгдэж байгаа ч дараах хүндрэл бэрхшээл байсаар л байна.

- ✓ МБС-ын стандартын дагуу ЧСС-ын сан бүрдээгүйгээс сургууль бүр харилцан адилгүй сургалтын хөтөлбөр ашиглаж байна. 2020-2021оны хичээлийн жилээс хэд хэдэн мэргэжлийн багш нарын оролцоотой улсын хэмжээнд агуулга нь ижил болгох ажил зохион байгуулагдаж байгаа нь сайшаалтай байна.
- ✓ Төгсөгчдийн ур чадварыг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа бүрэн төлөвшөөгүй байна.
- ✓ Нийгмийн түншлэлд тулгуурлан сургалтын дадлага, үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн өмнөх дадлага ажлуудыг чанаржуулах шаардлага байна.
- ✓ Ажил олгогчийн хэрэгцээнд нийцүүлэн элсэлтийг төлөвлөх төгсөгчдийн ур чадварыг сайжруулах шаардлага байна. Үүнд: Австралид ажил олгогчийн захиалгаар ажилтан бэлтгэдэг нь ажилгүйдэл байхгүй, тухайн ажилтанд шаардагдах ур чадварыг ажил олгогч тавьж түүний дагуу сургалтаа явуулдаг.

Нийгмийн түншлэл гэсэн асуудлаар нилээдгүй олон жил ярьж хэрэгжүүлэхийг оролдож байгаа ч тодорхой үр дүнд хүрэхгүй л байна. Үүний тод илрэл нь мэргэжлийн сургуулиудад тулгамдаад буй гол асуудлыг нэг болох үйлдвэрлэлийн дадлагын чанар юм.

График-1



2020-2021 оны хичээлийн жилд дадлага хаана хийсэн тухай судалгааг Нийгмийн түншлэлийн ажилтан Мандахаас авч аваад дүн шинжилгээ хийхэд нийт 40 өөд аж ахуйн нэгж дээр дадлага хийсэн байгаа нь бид цаашид жижиг том ААН нэгжтэй хамтран ажиллах боломж байна гэдгийг харж болно. Мөн Хамтран ажиллах гэрээтэй 4 ААН Шивээ Овоо ХК-нд нийт суралцагчийн 20 %, Петротак дээр 1%, МАК цемент ХК дээр 2% Улаанбаатар хотын БЦ дээр 0% хийсэн байгаа нь хамтран ажиллах , түншлэл хангалтгүй байгааг харуулж байна.



Мөн статистик хариуцсан мэргэжилтэн Ану-Үжингийн судалгаанаас

Мэргэжлийн боловсрол, сургалт, сургалт дахь ТХХТ-ийг сайжруулах арга замууд

Сургуулийн зүгээс оруулах хувь нэмэр

- ✓ Мэргэжлийн багууд болон хувийн хэвшлийн гүүр нь болох
- ✓ Мэргэжлийн боловсрол сургалт дахь түншлэлийг хөгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах багийг албан ёсоор ажиллуулах */багш нар, ажил олгогчдын төлөөл, менежерийн баг- үүн дээр ТУЗ-ыг холбож ярьж өгөх /*
- ✓ Багш солилцооны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх , туршлага судлах үйл ажиллагааг тогтмол хийх

- ✓ Ажил олгогчид сургалтын байгууллагатай хамтран ажиллах сонирхолыг татах, хөшүүргийг бий болгох хөгжүүлэх Энэ хүрээнд 2018 онд Германы хамтын ажиллагааны төслийн хүрээнд Үйлдвэрлэлийн дадлагажуулах сургагч багш бэлтгэх үйл ажиллагаа манай сургууль дээр зохион байгуулагдаж нийт 48 хүн үйлдвэр аж ахуйн газраас бэлтгэгдсэн хэдий ч түүнийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй явагдсаар байна. */татварын хөнгөлөлт, харилцан ашигтай нөхцөл тавих/*

Судалгаа-1 /Ярилцлагын аргаар/

Хамгийн олон жилийн ххамтын ажиллагаатай байсан Шивээ Овоо Хк ийн инженер Эрдэнэбаяр, Сургалт хариуцсан ажилтан Цэрэннадмид нартай утсаар холбогдон хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Тус ярилцлагаас

- Гэрээнд заасан нөхцөлөөр бол хамтын ажиллагаа дунд зэрэг байдаг
 - Хамтын ажиллагааны хамтрах хүрээ нь дадлага хийлгэх, үнэлгээ зохион байгуулахад хатран ажилладаг.
 - Дадлагад гаргахдаа цөөхөн хүүхэд байвал чанартай байдаг.
 - Цахилгааны, ҮТ ангийн суралцагчид мэдлэг чадварын хувьд сайн байдаг.
 - ХАБЭА ангийн суралцагчид идэвх санаачлагатай сайн ажилладаг.
 - Хүүхдүүд заримдаа хаяад явдаг.
 - ХММО-ын суралцагчид тааруу байдаг.
 - Гидроэкскаватор биш цахилгаан экскаваторын сургалтын эрх авч ажиллавал манай дээр далага хийх цаашлаад ажиллах боломжтой байна гэсэн нь хамтын ажиллагааг дадлага хийлгэх, үнэлгээ хийх ажлаар хязгаарлахгүй хөтөлбөр, сургалтын төлөвөлгөө хийх ажилд ч мөн татан ороцлуулах шаардалагатай гэж үзэж байна.
- ✓ Маркетингийн үйл ажиллагааны зардалын тодорхой хэсгийг түншлэл татах ажилд зарцуулах */сургалт үйлдвэрлэлийн зардал байж болох юм/*

Сургалтын албаны зүгээс

- ✓ Хамтран ажилладпаг байгууллагуудтай харилцаа холбоогоо байнга тогтмол явуулахын тулд баг бүрдүүлэх

- ✓ Ажлын байран дээр нь ажил олгогчидод сургалт явуулах. Ур чадварын уралдаан зохион байгуулах
- ✓ “Шинэ санаа- Шилдэг бүтээлийн үзэсгэлэн” тогтоосон хугацаанд уламжлал болгон явуулах ба үүнд түншлэгч байгууллагуудыг татан оролцуулах. Манай сургууль тус ажлын хүрээнд 2 жил дараалан ажлыг зохион байгуулж бусад аж ахуйн нэгж хэвлэл мэдээллийн алба урин бусдад түгээх ажлыг амжилттай зохион байгуулсан ба түүнд маш олон багш суралдцагч өөрийн бүтээл гаргаж байсан.

/шалгаруулалтаа түншлэгч байгууллага, багш, оюутан гэсэн 3 шатаар явуулах/


- ✓ Ажил олгогч, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах цаг гаргуулах */1 өдөр – ажлын цагаар үдээс өмнө , хойш чөлөөтэй байх, холбогдох шатны менежер удирдлагаар хангах/*
- ✓ Үйлдвэрлэлийн дадлага ажлыг системтэйгээр нарийвчлан зохион байгуулах */жишээ нь шивээ овоо ххк -д дадлага хийлгэхээр бөөн бөөнөөр нь явуулдаг. Үүний оронд холбогдох мэргэжил бүрээс жилд 1-2 оюутан, суралцагчийг ээлжийн ажлыг харгалзан үзэж заавал дадлага хийлгүүлэхээр гэрээ байгуулах, том үйлдвэр уурхайд дадлага хийх оюутнуудаа ирц идэвхи голч оноогоор жагсааж үйлдвэрлэлүүдэд хуваарилах манайхан ихэвчлэн өөрийн хамаатан садан танил талын хүүхдүүдээ түлхүү хуваарилах бөгөөд тэдгээр хүүхдүүд ирц идэвхи шаардлага хангалтгүй мэдлэг чадвар дадал тааруу учраас дараа дараагийн оюутнуудыг хүлээн авахдаа тун дурамжхан үл тоомсорлосон байдлаар хүлээн авдаг/*

Манай сургууль үйлдвэрлэлийн сургалт, дадлага хийх 5 байгууллаг ААН нэгжтэй гэрээ байгуулсан ажиллаж байгаа хэдий ч гэрээ дүгнэж ажилладаггүй, гэрээт байгууллага дээр дадлага хийж байгаа нь нийт суралцагчдын маш бага хувь байдаг байна.

График 2

Хоёр байгууллагын хамтын ажиллагаа ямар түвшинд байдаг вэ ?

■ Хангалттай ■ Боломжийн ■ Дунд зэрэг ■ Тааруу



Хамтран ажилладаг 5 ААН нэгж төгсөгчөөс байгууллагын хамтын ажиллагаа ямар түвшинд байдаг вэ гэсэн асуулгад

57 % нь дунд зэрэг, 29% нь хангалттай гэж хариулсан байгаа нь цаашид хамтын ажиллагааны арга хэлбэрийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хувь хүний зүгээс /мэргэжлийн багш анги хариуцсан багш/

- ✓ Бусад орны МБС-ын тогтолцоонд байгаа арга туршлагуудыг судлах
- ✓ Бусад ижил төстэй мэргэжлийн сургуулиудын туршлагыг судалж , өөрийн сургуульд хэрэгжүүлж болохуйц аргыг турших
- ✓ Хөгжиж буй аж ахуй нэгжүүдэд мэргэжлийн тал дээр дэмжлэг үзүүлж, улмаар тэдний анхаарлыг татах.

Өндөр хөгжилтэй орнуудаас монгол хэрэгжүүлж болохуйц туршлагууд.

Мэргэжлийн боловсрол сургалтын шинэчлэл нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх багш нарын заах арга зүй болон мэргэшсэн инженер техникийн ажилтны түвшинд хүргэж чадавхаржуулах, үйлдвэрлэлийн дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчиныг бүрдүүлэх чиглэлээр олон төсөлт хөтөлбөрүүд хэрэгжүүлж гадаадын

олон орноос тодорхой төсөлт хөтөлбөр хэрэгжүүлж багш боловсон хүчинт далагаажуулах, туршлаг судлах ажиглалтыг зохион байгуулсан билээ. Тухайлбал :

1. Темасек Сан – Синтапур техник мэргэжлийн сургууль -1

2. Австралийн Техник мэргэжлийн сургуулиудад -10

3. Холбооны бүгд найрамдах герман улсад -10 туршлага судлан ирсэн билээ.

Дээрхи орнуудын туршлагаас үзэхэд Монгол улсад хэрэгжүүлж болохуйц арга туршлагыг дараах байдлаар авч үзлээ.

1. Эхний цалин / бага хэмжээний цалинтай далага хийлгэх/

Таны анхны цалин таны боловсролыг сонгох шалтгаан байж болохгүй. Тэсн хэдий ч далагаажигчид тодорхой өндөр шалгуур тавьж тухайн шалгуурт тэнцсэн суралцагчийг далагажигч оюутны бага хэмжээний цалин олгох.

2. Туршлага хуримтлуулах

Далага ажлыг тухайн команднид олноор хамруулах биш тухайн компанийн ажлын онцлог бүтэц орон тоот харгалзан үзэж нэг мэргэжилтэнд нэг оюутанг хариуцуулсанаар тухайн ажлын далага туршлага хуримтлагдана. /жишээ нь албан байгууллага бүрт нярав, нягтлан, ХАБ,ЭА-н ажилтан байдаг/

3. Ажилд орох боломж

Тухайн далагажигч оюутан маань тухайн аж ахуй нэгж компанийн үйл ажиллагаанд ажилтаны зүгээс идэхитэй оролцож, ажил үүргээ биелүүлж чадвал төгсөх дараа жинхэнэ болж боломжтой болох юм.

4. Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх

Хэдий чинээ чадварлаг оюутан бэлтгэнэ төдий чинээ МБС-ын нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь өснө. Дараа дараагийн оюутнуудыг далага хийлгэх орчны асуудал шийдвэрлэгдэнэ гэсэн үг.

5. Далага ажил нь суралцахад түлхэц болохуйц байх

Үйлдвэрлэл дээр далагажсан оюутан үр чадварын хувьд хангалттай мэдээлэл, мэдлэг хуримтлуулсан айдат учир, онолын сургалтын явцад чухал түлхэц болох ба өөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж чадна.

6. Аж ахуйн нэгж ба сургууль хоорондын холбоо

Үйлдвэрлэлийн далагын явцад оюутнуудын хангалттай сайн ажиллаж чадсанаар байгууллага аж ахуй нэгж хоорондын хамтын ажиллагаанд улам их нөлөөлөх болно. Багш солилцоо, тогтмол далагын орчин, хөнгөлөлт эдлэх боломж.

7. Суралцах арга барил сонирхолыг нэмэгдүүлэх

Оюутнууд дадлага ажлыг үр дүнтэй сайн хийснээр суралцах идэвхи сонирхол нэмэгдэнэ.

8. Ажлын байран дахь алдагдлыг нөхөх

Аж ахйу нэгжүүд бага цалингаар дадлагажигч оюутан ажиллуулсанаар татварын хөнгөлөлт, бага зарлагаар их ажил амжуулах боломжтой.

Хамтын ажиллагааны нөхцөл байдлыг дээшлүүлэх чанарын шалгалт хийх

Дадалага сургалтын чанарыг сайжруулахын тулд хамт олноороо хамтран дадлага сургалтынхаа давуу болон үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд дараах хяналт шалгалтын хүснэгтийг ашиглаж болох юм.

1. Чанартай зорилтуудын талаар хэлэлцээр хийх. Бид хаашаа явахыг хүсч байна вэ?
2. Чанарын мэдлэгийг хөгжүүлэх
3. Хууль эрх зүйн орчныг ашиглах
4. Сургалтын байршил хоорондын хамтын ажиллагааг сайжруулах
5. Боловсролын ажилтануудыг мэрэгшүүлэх
6. Мэргэжлийн сургалтыг дадалгат шилжүүлэх
7. Сургалтын чанарыг нэмэгдүүлэх
8. Сургалтын үр дүнг нөөцлөх

Хамтын ажиллагааны нөхцөл байдлыг дээшлүүлэх чанарын шалгалт хийх хүснэгт

Гэрээний дугаар :	Бүх зүйл хэвийн		Үүнд арга хэмжээ авах ёстой
Чанартай зорилтуудын талаар хэлэлцээр хийх			
Сургалтын үнэ цэнэ, зорилгыг компаниудтай хматран тодорхойлох			
Бид сургалтын чанарыг тогтмол хянаж, шалгаж үздэг			
Сургалтыг сайжруулах үр дагавар нь энэхүү шалгалтын дүнгээс гардаг			
Хууль эрх зүйн орчныг ашиглах			
Сургалтын бүх хугацаанд үргэлжлэх компаний			

Сургалтын төлөвлөгөө байдал.			
Сургалтын төлөвлөгөө нь сургалтын журам, сургалтын хүрээний төлөвлөгөөнөөс гаралтай			
Сургалтын төлөвлөгөө, сургалтын нотлоог сургалтад хамрагдагсантай тогтмол ярицаж байдал			
Сургалтын байршил хоорондын хамтын ажиллагааг сайжруулах			
Компани нь мэрэжлийн сургуультай тогтмол солилцоо хийдэг			
Бид сургалтын байршлын түншүүдийн хамтын ажиллагааны байдлыг тогтмол шалгаж байдал.			
Хамтын ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар заавал биелүүлэх гэрээгүүд байдал			
Боловсролын ажилтануудыг мэрэгшүүлэх			
Сургагч багш нар техникийн хувьд чадварлаг бөгөөд сургалтын агуулгыг ойлгомжтой байлцаар дамжуулав			
Сургалтын мэрэжлэгчид агуулгыг ойлгомжтой байлцаар дамжуулах аргуудыг мэддэг			
Сургагч багш, мэрэгшсэн ажилчдыг мэрэгшүүлэх санал байна			
Мэрэжлийн сургалтыг далайг шилжүүлэх			
Компани нь ажилд зуучлах, сонгон шалгаруулах замаар шаардлагад нийцсэн хангалттай тооны залуу хүмүүсийг олдог.			
Өргөдөл гаргачийн сонгон шалгаруулалт эхлэх сургалт эхлэх хооронд компани залуучуудтай холбоо тогтооно			
Сургалтын эхлэл далайг/танилцуулах хавтас дамжуулан/			
Сургалтын чанарыг нэмэгдүүлэх			
Сургалтын арга, сургал хүмүүжүүлэх арга барил нь суралгачдын танилцуулга, хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал			
Далайг ажигчинд нь бодит ажил, бизнесийн үйл явцад оролцдог			
Сургалтад хамрагдах хүмүүс зөвхөн сургалттай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд сургалтын бус үйл ажиллагаа эрхэлдэггүй			
Сургалтын явц нь сонсогчдын хувьд ил тод байна			
Сургалтад хамрагдагсдын сургалтыг далайг яваа сургагч багш, сургалтын мэрэжлэгчтэй байдал.			

Сургалтын үр дүнг нөөцлөх			
Санал хүсэлтийн талаархи хэлэлцүүлэг байдаг. Сургалт хүлээн авч, сургалтанд хамрагдах боломжтой хичээлийн төгсгөлд.			
Сургалтын зорилтыг харилцан тохиролцож, тогтмол хугацаанд шалгаж үздэг			
Сургалтанд хамрагдах хүмүүс шалгалтын шаардлагын талаар цаг тухайд нь өөрсдөдөө мэдээлдэг.			

Дээрхи хяналт шалгалтыг хамт олон хамтран боловсруулж ажил ологогч, Төлөөлөн Удирдах Зөвлөөр хэлэлцүүлэн баталж гэрээ хэлэлцээр хийвэл үр дүнтэй санагдлаа.

/Германд болохоор 1-2 өлөр эсвэл 1-3 өдөр онолын мэдээлэл өгөөд нөгөө 2 өдөр нь дадлага хийлгэдэг. Үүн шиг хаб,э-н мэргэжлийн мэргэжлийн ангиудаар эхний 3 өдөр бүтэн онол орчихоод 4, 5 өдөр сургууль дээр онолтойгоо холбуулан ажилын даалгвар өгөөд сургууль дээр илрүүлдэг байсан.тэгээд дараа нь 1-3 өдрийн хичээл дээр хүүхэд нэг бүр тэр асуудлаас хэлэлцээд багшийн үнэлгээ, тухайн ажилыг хийхэд байсан хөндлөнгийн үнэлгээ, суралцагч суралцагчийн үнэлгээнүүдийн нийлбэрээр багшийн 70 оноог тооцож гаргаж байсан юм. Одоо болохоор ийм олон аж ахуй нэгжүүд байгаа юм чинь ХАБ,ЭА-н давтан зааварчилгаанд бүх аж ахуй нэгжүүдийн ХАБ,Эан ажилтангууд ирдэг юм тэдэнд нэг ажилтанд 1 хүүхэд хариуцуулаад тодорхой хугацаа заагаад 4, 5 өдрийн аль нэг өдрийг сонгоод тэр өдрөө бүтэн ажлын байран дээр нь дадлагажуулаад дараа нь оюутан бүр ажлын байран дээр хийсэн дадлага ажлыг нийтээр хэлэлцэж тулгамдсан асуудлыг нь шийддэг байвал сургууль дээр хийснээс илүү үр дүнтэй юм болов уу гэж бодсон. Нэржмаагийн анги анай анги хоёр дээр яг хэрэгжүүлээд үзсэн. Уул нь боломжийн хүүхдүүд бас хичээлээ ойлгоход хялбар байсан юм/. Би ирхийхээ өмнө барига хот тохижуулалтын нийт хаб,э-г хариуцсан ажилтангуудад марта багш бид 2 сургалт явуулсаны тэр сургалтанд дээр зухац асууж үзхэд бол асуусан хэдэн хүмүүс маань их л дуртай байсан . нэг нэг оутан дагалдуулаад л тэдний байгууллагын хаб,э-н бичиг баримт бүрдүүлэлт, юу шаардлагатай тэр мэдээллийг оюутнаар дамжуулан мэдээлэл солилцож байхаар, хэрхэн хяналт шалгалт хийдэг зэрэг онолын талын бүх мэдээлэлээр би хангаж өгөхөөр/ та санааг илтгэлийнхээ гол хэсэгт хэрхэн оруулах уу?

СУДАЛГААНЫ АЖИЛ, ДҮГНЭЛТҮҮД

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн техникчийн мэргэжлээр давтан зааварчилгаа өгдөг. Үүн дээр орон нутагт байгаа ХАБ,ЭА-н ажилтангуудаас судалгаагаа аваад долоо хоногийн 1 өдөр бүтэн 1 оюутанг хариуцуулан өгч ажлын байран дээр дагалдуулах саналыг хэлэлцэж тохирсолцох. Тэгсэнээр ХАБ,ЭА-н ажилтаны тулгамдаж буй асуудлыг тэр оюутанаар дамжуулах бичиг баримтыг зэгцлэх, багш мэргэжлийн зөвөлгөө өгөх асуудлыг шийдвэрлэхэд харилцан тусалцаа үзүүлнэ.

1. ХАБ,ЭА-н техникчийн мэргэжлээр нийт 35 оюутан суралцаж байна.

1-р курс – 15

2-р курс – 13

3-р курс - 7



2. Говьсүмбэр аймгийн хэмжээнд нийт хичнээн аж ахуйн нэгж компани үйл ажиллагаа явуулдаг вэ?

Барилга хот тохижуулалтын чиглэлээр -4

Үйлчилгээний чиглэлээр -35

Уул уурхайн чиглэлээр -5

Боловсролын чиглэлээр –

3. Таны ажлын явцад шинэ мэдээ мэдээлэл, ажлын арга барил дутагдах тохиолдол гардаг уу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Заримдаа

4. Өөрийн ажлын байран дээр тулгарсан асуудлаа хэрхэн шийдвэрлэж болох вэ?

- ☐ Сургалтанд хамрагдах
- ☐ Сургалтын байгууллагатай хамтарч ажиллах
- ☐ Мэргэжлийн хүнээс зөвөлгөө авах
- ☐ Бусад

5. Та МБС-ын байгууллагатай хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

- ☐ Мэргэжлийн багштай нь хамтран ажиллах
- ☐ Харилцан бие биедээ туслах/1 оюутан дагадлуулаад шаардлагатай мэдээлэлийг багш өгөх/
- ☐ Зааварчилгаа зөвөлөгөө авах

6. Танай байгууллага МБС-ын тухай хэр ойлголттой байдаг вэ?

- ☐ Хангалттай

- Дунд зэрэг
 - Хангалтгүй
 - Мэдэхгүй
7. Танай байгууллага Политехник коллежтэй хэр хугацаанд хамтран ажилласан бэ?
- 1-2 жил
 - 3-5 жил
 - 6 жилээс дээш
8. Хоёр байгууллагын хамтын ажиллагаа ямархуу түвшинд байдаг вэ?
- Хангалттай
 - Боломжийн
 - Дунд зэрэг
 - Тааруу
9. Танай байгууллага МБС-ын байгууллагатай ямар үйл ажиллагааг явуулдаг вэ?
- Үйлдвэрлэлийн дадлага төгсөлтийн шалгалт
 - Эд материалын дэмжлэг
 - Уралдаан зохион байгуулах
 - Хамтран сургалт явуулах
10. Танай байгууллага МБС-ын байгууллагад хөрөнгө оруулалт хийвэл татварын хөнгөлөлт эдэлдэг тухай мэдэх үү?
- Тийм
 - Үгүй

Тайлбар : 2009 оны татварын шинэчилсэн найруулгаар ААН-д татварын хөнгөлөлт эдлүүлэхээр 12,1,28 – 12,1,30 хүртлэх заалтуудаар оруулж ирсэн.

ДҮГНЭЛТ

Нийгмийн туншлэл хамтын ажиллагааны харишаа идэвхтэй хөгжсөн орнуудыг туршлагаас харахад уг ажиллагааны үйл ажиллагаа тус бүр дээр судалгаа шинжилгээ хийх шаардлагын улмаас Мэргэжлийн Боловсрол Сургалт туншлэлийг хэрэгжүүлэх ажлыг шинэ түвшинд гаргахыг хүсвэл нилээгүй ажлыг системтэй хийх шаардлагатай байна гэж дүгнэн үзлээ.

Үүнд :

- ✓ Орон нутгийн удирдлагууд болон аж ахуй нэгжүүдийн анхаарлыг татах талаар тодорхой бодит үр дүнтэй ажил хийх / шинэ санаа шилдэг бүтээлийг орон нутгийн хэмжээнд бүх аж ахуй нэгж, хувь хүн бүрийг хамруулах боломжтойгоор зохион байгуулах, багш солилцоог тогтмол зохион байгуулах, илтгэл хэлэлцүүлэг зохион байгуулах, TV-ын хурал зохион байгуулах түүн дээр тэрээ хэлэлцээр хамтран ажиллах талаар ярицах, МБС-ын талаархи ойлголтыг сургалт суралтатгалчид хийх/
- ✓ Нийгмийн туншлэл, гадаад дотоод харишааны мэргэжилтэнт хамтарсан баг ажиллуулах/ нийгмийн туншлэл хамтын ажиллагааны үйл ажиллагааг тогтмол хянах үйл идэвхижүүлэх, хамтын ажиллагааг чанаржуулах тал дээр тогтмол хяналт тавих, уг багт тодорхой санхүү мөнгө хөрөнгө төсөвлөх/
- ✓ Аж ахуй нэгжүүдэд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтийн бодлогыг нэмэгдүүлэх/ манай дотоод нөөц бололцооноос дээр тулгуурлан ажилтантай мэргэшүүлэх, спорт болон урлагийн зал хөнгөлөлтөөр ашиглуулах
- ✓ Нийгмийн туншлэлийн зөвлөлтөөн зохион байгуулах. Энэ зөвлөлтөөнөөр оюутны мэргэжлийн үр чадвар чадмжийг сайжруулах, дадлагажуулагч ААН, байгууллага болон дадлагажигч оюутнуудын уялдаа холбоог сайжруулах, дадлага ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажиглалтуулах талаар ярицах, шинийг хүрэх.

НОМ ЗҮЙ

1. Мэргэжлийн болон Техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр – 2016-2021 он
2. МБС-ын байгууллагын хамтын ажиллагааны талаархи эрдэм шинжилээний материал 2015 он
3. LEITFADEN Qualität der betrieblichen Berufsausbildung -2015
4. www.bibb.de/qualitaet
5. [www.berufsbildung -- qualitaet.de](http://www.berufsbildung--qualitaet.de)